



УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Чингисийн өргөн чөлөө 45, 3 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060
Утас: 34 16 74, Факс: (976-11) 34 30 61,
Цахим шуудан: info@ubedn.mn, Цахим хуудас: www.tog.mn

2024.01.18 № 1/104
танай _____-ны № _____-Т

Тодруулгын хариу хүргүүлэх
Тухай

Тодруулга 1:

Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагын ерөнхий шаардлагын 1.4-т санал болгож буй бүтээгдэхүүн нь УБЦТС ТӨХК-ийн Ухаалаг тоолуурын нэгдсэн системд бүрэн нийцэж холбогдон ажиллах нөхцөлийг хангасан байх ёстой гэсэн шаардлага тавигдсан байсан. УБЦТС ТӨХК-ийн энэхүү Ухаалаг тоолуурын нэгдсэн систем нь одоо ямар системээр ажиллаж байгаа вэ?

ТШЗ баримт бичгийн Ерөнхий шаардлагын 1.4-т санал болгож буй бүтээгдэхүүн нь УБЦТС ТӨХК-ийн Ухаалаг тоолуурын нэгдсэн системд бүрэн нийцэж холбогдон ажиллах нөхцөлийг хангасан байх ёстой. Гэсэн заасан систем нь яг аль системийг хэлж байгаа вэ?

Хариулт:

Одоогийн байдлаар УБЦТС ТӨХК-д БНЧУ-ын ZPA smart energy компанийн "ReadEN", БНХАУ-ын Chint electrics компанийн DDSI666, Shenzhen star instrument компанийн DDSF36C, DDS26D, Shenzhen Clou компанийн CL7100, Inhemeter компанийн SmartAMI болон ОХУ-ын РИМ компанийн РиМ гэх бие даасан ухаалаг тоолуурын системүүд ашиглагдаж байна.

Цаашид УБЦТС ТӨХК нь ашиглагдаж байгаа болон шинээр нэмэгдэх тоолуур, системүүдийг холбож нэгтгэсэн, Олон улсын чанар стандартад нийцсэн, компанийн өөрийн эзэмшлийн Ухаалаг тоолуурын нэгдсэн системийг нэвтрүүлэхээр төлөвлөсөн.

Иймд уг тендерийн шаардлагад тендерт оролцогч үйлдвэр компаниудаас тухайн санал болгож буй бүтээгдэхүүн (тоолуур, концентратор, HES систем)-ийг шинээр ашиглагдах системд холбоход шаардагдах тоолуураас HES системд мэдээлэл дамжуулахад ашиглагдаж байгаа нууцлалын стандарт, түлхүүр, нууцлалын протокол, шифрлэлтүүд, түүнийг тайлах аргачлалын мэдээллүүд, HES системээс ухаалаг тоолууруудыг алсаас тохируулахад ашиглагдах нууцлалын стандарт, өндөр түвшний нууц үг, нууцлалын түлхүүр, нууцлалын протокол, шифрлэлтүүд түүний тайлах аргачлалын мэдээллүүд зэрэг мэдээллийг УБЦТС ТӨХК-ийн эзэмшилд бүрэн хүлээлгэн өгөхөөр тусгасан.

Мөн нэгдсэн системтэй холболт хийх үед тухайн үйлдвэр, компани нь ямар нэгэн нэмэлт төлбөргүйгээр өөрийн зүгээс мэргэжлийн инженер техникийн ажилтнуудыг томилон ажиллуулж манай системд бүрэн холболт хийж хүлээлгэн өгөх үүрэгтэй байхаар тендерийн шаардлагад тусгасан.

Тодруулга 2:

Тендерийн зардалд тоолуурын баталгаажуулалтын зардлыг нэмж тооцох уу?

Хариулт:

Тендерийн зардалд тоолуур баталгаажуулалтын зардал ороогүй бөгөөд УБЦТС ТӨХК нь баталгаажуулалтын зардлыг хариуцна.

Тодруулга 3:

Тендерийн материалын техникийн тодорхойлолтын 2.1.11, 2.2.13-т заасан релений тасалж залгах үйлдэл IEC62055-31 стандартын дагуу бага ачаалалд $\geq 1 \times 10^6$ их гэдгийн тоон утга зөв эсэхийг тодруулж өгнө үү.

Хариулт:

Тоолуурын таслах релений тасалж залгах үйлдэл IEC62055-31 стандартын дагуу ачаалалгүй үед болон бага ачаалалд $\geq 1 \times 10^6$ -аас их гэдэг тоон утга зөв болно.

Тодруулга 4:

Тендерийн материалын техникийн тодорхойлолтын 2.4-н техник хангамжийн интерфэйс хэсэгт тусгасан алсын дохиог илрүүлэх-4 гэдгийг тодруулж өгнө үү.

Хариулт:

Концентраторт алсаас дохио хүлээн авах 4 сувагтай байна. Үүнд телесигналын 2 суваг болон релений гаралтын хяналт удирдлагын 2 суваг байна.

Тодруулга 5:

Тендерийн материалын техникийн тодорхойлолтын 1.6-д тоолуураа дагалдуулан өөрийн AMR (HES) системийг холбогдох эрхийн хамт үнэ төлбөргүй хүлээлгэн өгнө гэж тусгасан байна. Хэрэв нэг нийлүүлэгч 2 болон түүнээс дээш багцад ялагч болвол нэг AMR систем нийлүүлэх үү, эсвэл багц тус бүрт нэг AMR систем нийлүүлэх үү?

Хариулт:

Нэг нийлүүлэгч 2 ба түүнээс дээш багцад шалгарсан тохиолдолд тухайн нийлүүлэгчийн багц тус бүрт санал болгосон бүтээгдэхүүн нь зөвхөн нэг үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн бол нэг AMR систем нийлүүлж болно. Хэрэв багц тус бүрд өөр өөр үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн санал болгосон бол тус бүрийн AMR системүүдийг хүлээлгэн өгөх шаардлагатай.

Тодруулга 6:

Тендерийн материалын техникийн тодорхойлолтын 5.3-т тоолуурын цагт зориулсан нөөц тэжээлийн эх үүсвэр (батареи) нь 16 жилээс багагүй хугацаанд ажиллах гэж заасан байна. Энд заасан 16 жил гэсэн хугацаа зөв үү?

Хариулт:

Тендерийн техникийн тодорхойлолтын 5 дугаар бүлэг нь зөвхөн Багц-5-д хамаарах бөгөөд тусгай зориулалтын буюу тулгуурт шууд гадаа ил суурилуулж ашиглах зориулалттай 3 фазын 100А-ын тоолуур, концентраторт зориулсан шаардлагууд юм. Тус 5.3 дахь заалтад дурдсан 16 жил гэсэн хугацаа зөв болно.

Тодруулга 7:

Тендерийн бичиг баримтын 1.16 заалт дахь “Үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь 2-оос доошгүй өөр үйлдвэрлэгчийн ухаалаг тоолуурын системд амжилттай интеграци/холболт хийж ашиглаж байгаа туршлагатай байх” гэдэг нь тоолуурыг бусад үйлдвэрлэгчийн HES системтэй эсвэл HES системийг бусад үйлдвэрлэгчийн MDM системтэй холбохын аль нь болохыг тодруулж өгнө үү.

Хариулт:

Дээрх шаардлагад дурдсан үйлдвэрлэгчийн туршлага нь аль нь ч байж болох ба амжилттай интеграц хийж хэвийн ажиллаж байгаагаа нотлон ирүүлэх шаардлагатай юм.

Тодруулга 8:

ТӨХ-ийн ТШЗ 18.6.8-ын 13-т “Нийлүүлэх тоолуурт Монгол улсын хэмжих хэрэгслийн загварын туршилтын гэрчилгээ ирүүлэх, гэрчилгээгүй бол тоолуурыг нийлүүлэхээс өмнө загварын туршилтад орж гэрчилгээг авах тухай албан бичиг, нотлох баримтыг ирүүлэх” гэсний нотлох баримт гэдэгт ямар бичиг баримт орох вэ?

Хариулт:

Дээрх нотлох баримт гэдэгт нь Монгол улсын Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)-т импортлох эрх авах хүсэлт, загварын туршилтад оруулах хүсэлтээ өгсөн байх ба СХЗГ-т хандаж өгсөн хүсэлтүүд болон СХЗГ-аас хүсэлтийг хүлээн авсан, судалж байгаа нь үнэн болох тухай УБЦТС ТӨХК-д хандан ирүүлсэн тодорхойлолтыг тооцно. Техникийн тодорхойлолтын 1.8-д дурдсаны дагуу тоолуур нийлүүлэгдэх хугацаанаас өмнө Гэрчилгээг авсан байна.

Тодруулга 9:

Тендерийн материалын техникийн тодорхойлолтын 5.3-т Битүүмжлэл: IEC60529 эсвэл IP54 шаардлагыг хангасан байна. Хэрэглэгчийн 100А-ын тоолуур нь IP65 шаардлагыг хангасан байна гэж заасан байна. IP54, IP65-н аль шаардлагыг хангасан байх смтой вэ?

Хариулт:

Тендерийн техникийн тодорхойлолтын 5 дугаар бүлэг нь зөвхөн Багц-5-д хамаарах ба тус багцад зөвхөн тусгай зориулалтын буюу тулгуурт шууд гадаа ил суурилуулж ашиглах зориулалттай, хэрэглэгчийн 3 фазын 100А-ын тоолуур, концентратор худалдан авахаар байгаа тул 5.3 дахь заалтын IP65 битүүмжлэлийн шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Тодруулга 10:

Тендерийн 5-р багцын 1000ш 3 фазын 100А тоолуурыг PLC болон RF холболтын модулиас алийг нь сонгож нийлүүлэх вэ?

Хариулт:

Тендерийн шаардлагад холболтын модулийг үндсэн модуль нь PLC, нөөц модуль нь RF байхаар хосолсон модультай байна гэж тусгасан.

Тодруулга 11:

Тендерийн техникийн тодорхойлолтын дагуу тендер шалгаруулалтын өмнөх хугацаанд барааны загваруудыг үйлдвэрлэж, нийлүүлэх боломжгүй болсон тул энэхүү загваруудыг тендер шалгаруулалтын хянан үзэх хугацаанд өгч болох уу?

Мөн шаардлагатай үзүүлэлтүүдэд тохирсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч талаас нийлүүлэх хүсэлтэй буй тул тендер өгөх хугацааг сунгаж өгнө үү.

Хариулт:

Тендерийн баримт бичгийн ТШЗ 18.6.8 11.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө нийлүүлэх тоолуур, концентратор тус бүрээс загвар ирүүлэх ба загвар дугуу ирүүлсэн, огт ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.

Мөн тендер хүлээн авах эцсийн хугацаа ТШЗ 25.1 Огноо: 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Цаг: 09 цаг 00 минут

Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй гэж тус тус заасан.

Тодруулга 12:

ТШЗ 18.6 Ижил төстэй гэрээний туршлагыг 2020,2021,2022 онуудад ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээнүүдийн нийлбэр тухайн багцын төсөвт өртгийн 50%-аас багагүй үнийн дүнтэй байх шаардлага нь он тус бүрээр тооцох гээд байна уу эсвэл онуудын нийлбэрээр хангах гээд байна уу аль болохыг тодруулж өгнө үү

Хариулт:

Ижил төстэй гэрээний туршлага: 2020, 2021, 2022 онуудын ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээнүүдийн нийлбэр тухайн багцын төсөвт өртгийн 50%-иас багагүй үнийн дүнтэй байх шаардлагатай.

Тодруулга 13:

ТШЗ 18.3-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгийг тухайн оролцох гэж буй багцын төсөвт өртгийн дүнгээр тооцох уу эсхүл нийт багцуудын төсөвт өртгийн нийлбэр дүнгээр тооцох уу?

Хариулт:

ТШЗ 18.3 Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ төсөвт өртгийн 50% -иас багагүй байх (тухайн оролцох багцын төсөвт өртгийн дүнгээр тооцох ба 2 буюу түүнээс дээш багцад шалгарах болзол хангасан тохиолдолд түргэн хөрвөх хөрөнгийг гэрээний дүнгийн нийлбэрээс бодож тооцно.

Тодорхойлолтод багцын дугаар болон ажлын нэрийг заавал бичиж ирүүлнэ.

Тодруулга 14:

Гэрээний тусгай нөхцөлийн ГЕН.3.9-д төлбөрийг хэсэгчилсэн төлөх тохиолдолд гээд төлбөр төлөх үе шатны хугацааг 2025 оны 12 дугаар сар хүртэл 5 үе шатаар тусгажээ. Энэ нь төлбөр төлөх графикайг заавал мөрдөхгүйгээр бүтээгдэхүүнээ танай агуулахад бүрэн хүлээлгэн өгсний дараа бүх төлбөрөө авах боломжтой юм байна гэж ойлгож болох уу ?

Хариулт:

Тендерийн баримт бичигт заасан хугацаанд бараа материалыг бүрэн нийлүүлэх үүрэгтэй бөгөөд бараа нийлүүлэх хугацаа нь төлбөр төлөх хугацаатай хамааралгүй. УБЦТС

ТӨХК-ийн ухаалаг тоолуурын системийн төслийн санхүүжилтийг ЭХЗХ-ноос батлагдсан тарифын зохицуулалтаар санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн тул ТББ-т заасан төлбөрийн хуваарьт хугацаагаар санхүүжүүлнэ.

Санхүүжилтүүд он дамжиж төлөгдөх учраас нэмэлт санхүүгийн зардлыг төсөвт өртөгт тооцоолсон болно.

Тодруулга 15:

Нэг фазын тоолуур, мэдээлэл дамжуулах концентраторт урт, өргөн, өндрийн хэмжээ заасан шалтгаан, үндэслэл юу вэ?

Хариулт:

УБЦТС ТӨХК нь энэхүү тендерээр нийлүүлэгдэх тоолууруудыг одоогийн ашиглагдаж байгаа гэр хорооллын тоолуурын нэгдсэн хайрцаг, орон сууцны давхар дундын самбаруудад одоо байгаа тоолуурын оронд шууд сольж суурилуулахаар төлөвлөсөн. Иймд одоо байгаа тоолуурын хайрцаг, самбаруудын олон янзын овор хэмжээ, түүнд угсрагдсан таслах залгах тоноглол, монтажны утас, оруулга болон хэрэглэгчийн кабель утаснууд болон бусад тоноглол зэрэгтэй уялдуулан байж болох хамгийн том хэмжээг тусгаж өгсөн. Мөн концентраторын хувьд одоо байгаа агаарын дэд өртөө, иж бүрдмэл дэд өртөө, хаалттай дэд өртөөнүүдэд ерөнхий тоолуурын хамт шууд угсрагдах тул самбарын овор хэмжээ, бусад тоноглолын монтаж, угсралтын байдалд уялдуулан овор хэмжээг тусгаж өгсөн.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН



**УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ**

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Чингисийн өргөн чөлөө 45, 3 дугаар хороо,

Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060

Утас: 34 16 74, Факс: (976-11) 34 30 61,

Цахим шуудан: info@ubedn, Цахим хуудас: www.tog.mn

2024.01.16 № 1/80

танай _____-ны № _____-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Манай компани 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр “Ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх төсөл” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан.

Уг нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичгийн “Гэрээний тусгай нөхцөл”-ийн Бараа хүлээлгэн өгөх нөхцөл хэсгийн 6-д заасан “УБЦТС ТӨХК-ийн ашиглаж буй SmartAMI системтэй холбож туршсан протокол, холбогдох бичиг баримтууд” гэснийг хасахаар шийдвэрлэсэн тул та бүхэн энэхүү өөрчлөлтийг тендерийн материал бэлдэх явцад анхаарч, техникийн шаардлагад нийцүүлэн ажиллахыг хүсэе.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН

3170602924